



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар ус, дулаан дамжуулах төвийн насосын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд бий болсон 27 нэрийн, нийт 78,955,000.00 (далан найман сая есөн зуун тавин таван мянган) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 18 ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



**"Багануур дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд,
бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Ялтсан бойлер	3 Гкал/цаг	ш	1	28,500,000.00	28,500,000.00
2	Өргөх насос	160 м3 40 h/m	ш	2	8,500,000.00	17,000,000.00
3	Буцаахгүй клапан	ф150	ш	2	85,000.00	170,000.00
4	Хаалт	ф150	ш	8	135,000.00	1,080,000.00
5	Хог шүүгч	ф150	ш	4	125,000.00	500,000.00
6	Манометр	16кгс/см2	ш	10	70,000.00	700,000.00
7	Термометр	0-130С	ш	10	42,000.00	420,000.00
8	Давтамж хувьсгуур	35 квт	ш	2	7,000,000.00	14,000,000.00
9	Даралт тохируулагч	ф150	ш	1	2,900,000.00	2,900,000.00
10	Температур тохируулагч	ф150	ш	1	2,900,000.00	2,900,000.00
11	ПТ датчик	16 м3	ш	2	215,000.00	430,000.00
12	Гадна агаарын датчик	t=-45С	ш	1	450,000.00	450,000.00
13	Температур датчик	135С	ш	2	280,000.00	560,000.00
14	Цахилгаан удирдлагын шит		ш	1	1,922,500.00	1,922,500.00
15	Фланц	Ф125	ш	4	13,000.00	52,000.00
16	Фланц	Ф150	ш	40	13,000.00	520,000.00
17	Шилжүүлэг	Ф125-150	ш	4	6,500.00	26,000.00
18	Шилжүүлэг	Ф150-219	ш	4	7,500.00	30,000.00
19	Отвод	Ф150	ш	18	6,500.00	117,000.00
20	Ган муфьт	Ф15	ш	20	5,500.00	110,000.00
21	Па	Ф15	ш	20	5,000.00	100,000.00
22	Гайк боолт	M16	ш	300	5,500.00	1,650,000.00
23	Винтель	Ф15	ш	20	8,500.00	170,000.00
24	Хаалт	Ф50	ш	20	65,000.00	1,300,000.00
25	Дулаалтын материал	Ф150	ш	60	13,000.00	780,000.00
26	Шугам хоолой	Ф150	ш	60	42,000.00	2,520,000.00
27	Бөмбөлгөн хаалт	ф15	ш	5	9,500.00	47,500.00
НИЙТ ДҮН						78,955,000.00 (далан найман сая есөн зуун тавин таван мянга)